

БАТЛАВ.
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
ДАРГА *(Гарын үсэг, тамга)* Ц.ШАРАВЖАМЦ

**“DAWA-2017” НЭРЭМЖИТ ҮЗЭСГЭЛЭНТ УЛААНБААТАР
ӨРТӨӨТ МАРАФОНЫ ОЛОН УЛСЫН АНХДУГААР
ТЭМЦЭЭНИЙ УДИРДАМЖ**

Нэг. Зорилго

“Dawa” цомын нэрэмжит Монголын “Үзэсгэлэнт Улаанбаатар”-2017 олон улсын өртөөт марафоныг эх орондоо зохион байгуулах, Монгол улсад ирсэн гадаадын жуулчид, гүйлтийн спорт, болон спортоор хичээллэгчид, байгууллага хамт, олон, гэр бүл, иргэдийг биеийн тамир, спортын үйл ажиллагаанд өргөнөөр оролцуулах, эрүүл амьдралын төлөө хамтран ажиллах арга барилд суралцах, Монгол Улсыг олон улсад сурталчлахад оршино.

Хоёр. Зохион байгуулагчид

Ерөнхий зохион байгуулагчаар: Засгийн Газрын Хэрэгжүүлэгч Агентлаг
Биеийн Тамир, Спортын Газар
Хамтран зохион байгуулагчаар: Нийслэлийн Засаг даргын Тамгын газар,
Нийслэл биеийн тамир спортын хороо,
Grand china sport холбоо ажиллана.

Гурав. Тэмцээнийг зохион байгуулах хугацаа байршил

“Dawa-“ цомын нэрэмжит Монголын “Үзэсгэлэнт Улаанбаатар-2017” өртөөт марафоны олон улсын анхдугаар тэмцээнийг Улаанбаатар хотод 2017 оны 08 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулна.

Дөрөв. Тэмцээний ангилал, төрөл, оролцох бүрэлдэхүүн

А буюу “Жуулчин” ангилалд нийт 500 хүртэл хүн буюу 2-3 хүний бүрэлдэхүүнтэй 167-250 баг оролцоно.

В буюу “Аав ээж би-гэр бүл” ангилалд нийт 500 хүртэл хүн буюу 2-3 хүний бүрэлдэхүүнтэй 167-250 баг оролцоно.

С буюу “Найзууд” ангилалд нийт 500 хүртэл хүн буюу 2-3 хүний бүрэлдэхүүнтэй 167-250 баг оролцоно.

Д буюу “Сэтгэлд хоногшсон Улаанбаатар” ангилалд нийт 500 хүртэл хүн буюу 2-3 хүний бүрэлдэхүүнтэй 167-250 баг оролцоно.

Багийн бүрэлдэхүүнд гишүүдийн 1 нь заавал бусад бусад оролцогчийнхоо эсрэг хүйсийн хүн байна. Жишээ нь: 1 эрэгтэй + 1 эмэгтэй, 2 эрэгтэй + 1 эмэгтэй, эсвэл 2 эмэгтэй + 1 эрэгтэй байх

- ❖ Тэмцээний "Жуулчин" гэсэн ангилалд зөвхөн гадаадын иргэн 2-3 хүн нэг баг болж оролцоно.
- ❖ "Гэр бүл" гэсэн ангилалд гэр бүлийн гишүүд 3-11 насны 1 хүүхэдтэй /аав+ээж+хүүхэд, эсвэл өвөө+эмээ+хүүхэд, аав+хүүхэд, ээж+хүүхэд г.м/ 2-3 хүний бүрэлдэхүүнтэй баг оролцоно.
- ❖ "Найзууд" ангилалд 18 ба түүнээс дээш насны 2-3 хүн нийлж нэг баг болж оролцоно.
- ❖ "Сэтгэлд хоногшсон Улаанбаатар" ангилалд 50-65 хүртэлх насны ахмад 2-3 хүн баг болж оролцохыг зөвшөөрнө.

Ангилал тус бүр 5 өртөөтэй байна. Тэмцээнд 2-3 хүн нийлж баг болж оролцоно. Багууд тухайн бүртгүүлэн оролцож байгаа ангиллынхаа 5 өртөөг дамжин өгөгдсөн даалгавруудыг бүрэн биелүүлж барианд орсноор тэмцээнийг дуусгана. Хамгийн богино хугацаанд тухайн ангиллынхаа 5 өртөөг туулж, даалгаврыг зөв биелүүлсэн баг ялагч болно. Өртөө бүр дээр оролцогчдын цагийг бүртгэнэ.

Тав. Бүртгэлийн хугацаа, байршил

Өртөөт марафон тэмцээнд оролцохыг хүсэгчид онлайнаар болон биеэр ирж бүртгэлд хамрагдах боломжтой.

Бүртгэлийг 2017 оны VIII/01-10-ний хооронд Спортын төв ордны 1 давхарт хийнэ.

Тэмцээнд оролцогчийн тоо хязгаартай бөгөөд ангилал тус бүрт 167-250 баг буюу 500 хүртэл оролцогчийг бүртгэж бүртгэлийг хаана.

Бүртгэлд хамрагсан хүмүүст мандат, фудболк, цүнх, оролцогчийн дугаар, бугуйн чип буюу хугацаа уншуулагчийг олгоно

Бүртгэлийн мэдээллийг БТСГ-ын вебсайт руу нэвтэрч Mongolia Beautiful Ulaanbaatar International Orienteering Marathon хаягаар авна уу.

Бүртгүүлсэн багууд 2017 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн 8:00 цагаас эхлэн Сүхбаатарын талбай дахь бүртгэлийн асарт ирж, багийн бүртгэлээ дахин баталгаажуулаад Сүхбаатарын талбайд байршуулсан өөрсдийн оролцох ангиллыг заасан хаягийн ард очиж байраа эзэлнэ.

Зургаа. Тэмцээний гараа болох газар, хугацаа, шүүгчийн бүрэлдэхүүн

Тэмцээний Эхний гарааг Сүхбаатарын талбайгаас 2017 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн 10:00 гаргах бөгөөд 11:00 минутад багтаан бүх гарааг гаргаж дуусгана.

Тэмцээний гарааг ангилал тус бүрээр багуудыг нэгтгэн хэсэг хэсэг болгон ээлжлэн гаргах бөгөөд багийн гишүүд гараанаас гарахдаа бугуйвчаа чип уншигчид уншуулснаар тухайн багийн цаг тоологдож эхлэнэ. Багууд нийт зам өртөөгөө туулж, 5 тамгаа бүрэн даруулан барианы шугамд ирж бугуйвчаа хугацаа / чип/ уншигчид уншуулснаар тэмцээнээ дууссанд тооцно.

Хэсэг бүрийн хоорондын гараанд гаргах хугацаа 3 минут байна. Гарааг хэсэг тус бүрт 30-40 баг буюу 80-100 хүний бүрэлдэхүүнтэй байхаар зохион байгуулна.

Өртөөт марафоны гараа бариа, өртөө бүрт Биеийн Тамир, Спортын Газраас томилогдсон шүүгчид, сайн дурын ажилтнууд ажиллаж оролцогчдод зааварчилгаа өгөх буюу үнэлгээ өгнө.

Ангилал тус бүр 5 өртөөтэй байна. Оролцогч багууд 2-3 хүний бүрэлдэхүүнтэй байна. Багууд тухайн бүртгүүлэн оролцож байгаа ангиллынхаа 5 өртөөг дамжин өгөгдсөн даалгавруудыг бүрэн биелүүлж барианд орсноор тэмцээнийг дуусгана. Хамгийн богино хугацаанд тухайн ангиллынхаа 5 өртөөг туулж, даалгаврыг зөв биелүүлсэн баг ялагч болно. Өртөө бүр дээр оролцогчдын цагийг бүртгэнэ.

Долоо. Оролцогчдод тавигдах шаардлага

Тэмцээнд оролцож байгаа багийн гишүүд тэмцээний туршид зохион байгуулагчдаас өгсөн фудболкийг заавал өмсөж, биед эвтэйхэн чөлөөтэй спортын зориулалтын өмд гутал өмссөн байна.

Оролцогчийн дугаараа цээжний өмнө хэсэгт шүүгчдэд харагдахаар тогтоож байршуулсан байна.

Оролцогчдод өгсөн бугуйвч буюу хугацаа уншигчийг ямарч нөхцөлд хаяж гээгдүүлж, гэмтээж болохгүй бөгөөд барианд орсны дараа шүүгчид буцаан өгнө.

Бүх оролцогчид тэмцээний нээлтийн ажиллагаанд заавал оролцоно.

Тэмцээний нээлтийн ажиллагааны дараа гарааны шугамд дарааллын дагуу багийн гишүүдэд зам маршрут болон даалгавар бүхий хуудсыг тараан өгөх бөгөөд бусдад үзүүлж, тараахгүй байх ёстой.

Тэмцээний явцад бусад багийн оролцогчдод зам маршрутыг хэлж өгөх, даалгавар биелүүлэхэд нь туслахыг зөвшөөрөхгүй.

Тэмцээнд оролцогчид өгөгдсөн заавар журмыг чанд сахиж, замын хөдөлгөөний дүрмийг биелүүлэн, өөрсдийн аюулгүй байдлыг хангаж оролцох, байгаль орчинд хохирол учруулахгүй хог хаягдал хаяхгүй байх ёстой.

Тэмцээний дүрэм зааварчилгааг зөрчсөн үйлдэл гаргасан буюу биелүүлээгүй багт торгуулийн оноо өгөх буюу тэмцээнээс хасах хүртэл арга хэмжээ авна.

Оролцогч багууд шүүгчдээс олгосон зураглалын дагуу дараагийн өртөөнийхөө байршилыг тогтоон явганаар болон нийтийн тээврээр явж, хайж олно.

Өртөө болгон дээр шүүгчдээс өгсөн сонирхолтой даалгаврыг гүйцэтгээд зохион байгуулагчдаас өгсөн хуудсан дээрээ буюу биеийн аль нэг хэсэг дээрээ тухайн өртөөний тэмдэг, дардасыг даруулаад дараагийн өртөөнийхөө байршлын зураглал, даалгаврыг авч тэмцээнээ үргэлжлүүлнэ.

Багууд зөвхөн сонгон оролцож байгаа ангиллынхаа зам, өртөөг олж, өгөгдсөн даалгавруудыг биелүүлнэ. Өөр ангиллын өртөөг андуурч очсон тохиолдолд өртөөнд цагийг бүртгэхгүй бөгөөд даалгавар биелүүлэх боломж өгөхгүй бас хуудсыг тамгалж өгөх боломжгүйг анхаарна уу.

Багийн бүх гишүүд оролцож байгаа ангиллынхаа зам, 1-5 хүртлэх өртөөг бүрэн туулж, барианы шугамд ирж бугуйвчаа хугацаа /чип/ уншигчид уншуулснаар тэмцээнээ дуусгасанд тооцно.

Тэмцээнд оролцогчдыг өртөө хооронд явганаар, нийтийн тээврээр, явахыг зөвшөөрөх бөгөөд дугуй, авто машин taxi зэрэг бусад тээврийн хэрэгсэл ашиглахыг хориглоно. Оролцогчид нийтийн тээвэрт гарах зардлыг өөрсдөө хариуцна.

Найм. Багийн амжилт хүчингүй болох , тэмцээнээс хасагдах нөхцлүүд

Тэмцээнд оролцогч багууд өртөө алгасах, аль нэг өртөөнд цагаа бүртгүүлээгүй дараагийн өртөө рүү явах,

Бугуйвчаа гэж үрэгдүүлэх, гэмтээсний улмаас цагаа уншуулах боломжгүй болсон,

Тэмцээний дундуур багийн гишүүн буюу оролцогчоо солих

Энгэрийн дугаараа зааврын дагуу цээжиндээ биш өөр газар хадсан.

Тэмцээний явцад хориглосон тээврийн хэрэгсэл унаа ашигласан.

Зам маршрут өртөөгөө олох, даалгавраа биелүүлэхэд бусдаас дэмжлэг туслалцаа авсан буюу бусдад туслалцаа үзүүлсэн

Тэмцээний талбайд зөвшөөрөлгүй орж, шүүгчдийн ажил, бусад багийн даалгавраа биелүүлэхэд саад учруулсан

Тэмцээний явцад замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн, байгаль орчинд хохирол учруулсан

Тэмцээний зохион байгуулагчдаас өгсөн хувцасыг өмсөөгүй, өмссөн хувцас нь тэмцээний шаардлагад нийцээгүй.

Хугацаанаас өмнө зам маршрутын болон даалгаврын талаарх мэдээллийг авахын тулд зураг авах буюу видео төхөөрөмж ашиглан бичлэг хийх

Тэмцээний явцад зөвшөөрөгдөөгүй тоног төхөөрөмж ашиглах

Заагдсан зам маршрутын дагуу яваагүй

Бусдаас мэдээлэл авах буюу бусдад мэдээлэл өгөх зорилгоор утсаар дохио дуудлага хийх, ярих

Тэмцээний явцад спортын бус зохисгүй авир гаргах

Тухайн багийн амжилтад нөлөөлөх зорилгоор зохион байгуулагч болон шүүгчдийн зүгээс дэмжлэг үзүүлэх зэрэг тохиолдолд багийн үзүүлсэн амжилтыг хүчин төгөлдөр бус гэж үзэж дүнд оруулахгүй болно.

Ес. Анхаарах зүйлс

Нэг оролцогч нэг ангилалд оролцох бөгөөд өөр ангилалд давхардаж оролцохгүй, гэрлэн дохио, явган хүний гарцаар гараагүй буюу хөдөлгөөний аюулгүй байдлыг зөрчсөн оролцогчдод торгуулын оноо нэмэгдэнэ. Оролцогч бүр аюулгүй байдлаа хангаж оролцоно.

Оролцогч багууд тэмцээний зам маршрутыг тооцоолж, замын хөдөлгөөний дүрэм аюулгүй байдлыг чандлан сахиж мөрдөнө.

Орон нутгаас оролцогчид ирэх, буцах замын зардал болон байр, хоолны зардлаа өөрсдөө хариуцна.

Тэмцээний үед оролцогчдын өөрсдийн буруугаас болж гарсан хохирлыг тэмцээн зохион байгуулагчид хариуцахгүй.

Тэмцээнд оролцогчид Сүхбаатарын талбайд байршуулсан болон даалгаврын хуудас дээр тавигдсан тэмдэг тэмдэглэгээ бүхий байршлуудаас уух

ус, эмнэлэгийн тусламж зэрэг шаардлагатай тусламжуудыг авч болохыг анхаарна уу

Тэмцээнтэй холбоотой маргаантай асуудлыг тэмцээн дуусахаас өмнө бичгээр авч тэмцээний хяналтын шүүгчид хэлэлцэж, хариуг өгч шийдвэрлэнэ.

Арав. Шагнал урамшил

Гараанаас бариа хүртлэх хугацаа, торгуулын оноо зэргийг нэмж дүнг гаргана. Төрөл тус бүрд эхний Нэгдүгээр байр эзэлсэн багийг Цом, гишүүдийг алтан медаль өргөмжлөл гадаадад аялах эрхийн бичиг, 2, 3 дугаар байранд орсон багийн гишүүдийг мөнгө хүрэл медаль, өргөмжлөл, гадаадад аялах эрхийн бичиг бичгээр тус тус шагнаж урамшуулна.

Холбоо барих утасны дугаар 96464746, 51266243

**ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗАР**